

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**

**УЛС ТӨР**

ЭМЭГТЭЙ ГИШҮҮДИЙН АЙЛЧЛАЛ НЭРТЭЙ “ЗУГААЛГА” ТАСРАХГҮЙ НЬ

II нүүрт

**ДЭЛХИЙ**

БНАСАУ ПУУЖИНГИЙН ХӨДӨЛГҮҮР ТУРШЛАА

IV нүүрт

Дугаарын **60** мөр

Анагаах ухаан хөгжөөд байхад аспирын, цитрамоноо хэрэглэсээр л байх уу

Б.ДАВАА

**ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА**

## 7 АЙМААЧИД ЗАВШИЖ, ЖОЛООЧ НАР ХОХИРЧ ҮЛДЭХ НЬ...

Н.БАТЗАЯА

“Замын цагдаагийн газраас шалгалт нэрийн дор жолооч нарыг торгож, улсын төсөвт дөрвөн тэрбум төгрөг төвлөрүүлнэ” гэсэн мэдээлэл цахим ертөнцөд цацагдаж, иргэдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлээд буй. Тэр бүү хэл энэхүү хяналт, шалгалтыг дагаад галын хор, эмийн сангийн бизнес хүртэл дэлгэрч, аль хэдийн эрэлт хэрэгцээтэй бизнесийн тоонд орох боллоо. Үүнийг дагаад худалдаж авсан хор, ослын гурвалжин нь чанарын шаардлага хангаагүй байсан гэж бухимдах жолооч нар ч цахим ертөнцөд гарч ирэв. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн дугаарын сурвалжлагаараа Замын цагдаагийн газрын хяналт шалгалт болон түүнийг тойрсон бизнесийн асуудлыг хөндөн сурвалжлав.



“Жор мэдэхгүй эмчээс зовлон үзсэн чавганц дээр” гэх үг бий. Хүн бүрийн мэдэх энгийн үг атлаа монголчуудын өнөөгийн байдал, эмийн зохисгүй хэрэглээг тов тодорхой огуулжээ. Жишээ дурьда. Саяхан манай улсад нэгэн солонгос эмч ирж, ажилласан аж. Түүний зорилго нь өвчтэй зовлонтой хүмүүсийг эмчилж, оношлох юм байх. Гэвч ирсэн анхны өдрөөсөө л залуу нэг зүйлд гайхан баймагджээ. “Ямар зовиур илэрч байна вэ” гэх эмчийн асуултад анхны өвчтөн нь л “Миний зурх өвдөөд” гэж хэв нэг хариулсан байх юм. Монголд бол энгийн тохиолдол авч, гадаадын тэр эмчид тун гайхам явдал байсныг танилдаа дурьдсан байна.

**ЗЦГ улсын төсөвт дөрвөн тэрбум төгрөг төвлөрүүлнэ гэдэг ташаа мэдээлэл**

Замын цагдаагийн газар, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран наймдугаар сарын 29-өөс есдүгээр сарын 30 хүртэлх хугацаанд улс орон даяар “Хяналт, шалгалт” аяныг өрнүүлж байгаа билээ. Тус аяны хүрээнд улсын хэмжээн дэх тээврийн хэрэгсэл стандартын

шаардлага хангаж байгаа эсэх болон автомашины өнгө үзэмж, бүрэн бүтэн байдал, салхины шил цуурсан, машины улсын дугаар бүдгэрсэн, гэрэл дохно, цацруулагч, ослын гурвалжин, эмийн сан, галын хор зэргийг шалгаж байгаа юм. Шалгалтын үед Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасанчлан дээрх шаардлагын аль нэгийг биелүүлээгүй тохиолдолд жолооч нарт 19200-92000 хүртэл төгрөгийн торгууль ногдуулж байгаа аж.

## П.ЦАГААН: АН-ЫН ШИНЭЧЛЭЛ ДҮРМЭЭ МӨРДДӨГ ДАРГАТАЙ БОЛОХООС ЭХЭЛНЭ

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

**ҮЗЭЛ БОДОЛ**



**Шинээр олгосон зээл /салбараар/**



## ЗАСГИЙН ГАЗАР БАНКНЫ СЕКТОРЫН МӨНГИЙГ ХАМЖ, ИРГЭДЭД ЗЭЭЛ ОЛДОХГҮЙ БОЛОХ НЬ

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улс эдийн засгийн хямралд өртөж, хэзээ хэзээгүй дампуурах дээрээ тулчихаад байгаа. Яаралтай арга хэмжээ авахгүй бол ойрын хугацаанд дампуурах орнуудын жагсаалтад багтчихсан байна. Эдийн засгийн өсөлт тэр чигтээ зогсоод, бүр дефляци үүсчихлээ. Хэдийгээр улирлын чанартай гэж байгаа ч энэ янзаараа эдийн засаг унаад, иргэдийн худалдан

авах чадвар буураад байвал тийм ч сайн үр дүнд хүрэхгүй л байх. Ядаж байхад бондын эргэн төлөх хугацаа хэзээ хэзээгүй дөхчихөөд байдаг. Гэтэл Засгийн газраас дорвитой арга хэмжээ огт авсангүй. Төсвөө сахилга баттай болгож, хэмнэж болох бүхнээ хэмнэе гэж байсан ч тэгсэнгүй. 20, 30 сая төгрөгийн цалинтай дарга нарынхаа “бүс”-ийг жаахан чангалтыг гэж байснаа ч больсон. Баахан татвар авах гэж байснаасаа ухрав. Учир нь

орон нутгийн сонгууль болох гэж байгаа болохоор тэр. Гэтэл өнөөдөр сонгуульд санаа зовоод сууж байх үе мөн үү. Ядахад яргэгчээр хэзээ хэзээгүй “муужирч унах” гэж байгаа эдийн засгаа сэхээхийн оронд дээрээс нь “алх”-аар цохьчихлоо. Учир нь Засгийн газар өнгөрсөн даваа гарагт 15 тэрбум төгрөгийн үнэ бүхий хоёр төрлийн бонд худалдаанд гаргалаа.

**ОРОН, НУТГИЙН СОНГУУЛЬ-2016**

## Д.Эрдэнэбат: Энэ удаа МАН-ын ухралтыг зогсоох хариуцлагатай сонгууль болно

Ж.ОТГОН

УИХ-ын гишүүн, АН-ын орон нутгийн сонгуулийн менежер Д.Эрдэнэбат цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. Улсын хэмжээнд сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд 7006 мандатын төлөө 15209 нэр дэвшигч өрсөлдөхөөр бүртгүүлээд буй. Нийт нэр дэвшигчдийн 7500 орчим нь Ардчилсан намын гишүүд байгаа аж. Мэдээллийн эхэнд тэрбээр “Орон нутгийн сонгууль АН төдийгүй ардчиллыг дэмждэг улс төрийн хүчний хувьд онцгой юм. МАН-ынхан үйл ажиллагаа эхлэхдээ улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд яаран дүгнэлт хийж, улс орны амьдралд үл эргэлзэх байдал үүсгээд байна. Хэдийгээр АН-ыг муулах гэж үйл ажиллагаагаа явуулсан хэдий ч эргээд ард түмний амьдралыг муутгах зүйл рүү хэлтгийж байгаа нь байж болзошгүй гэж харж байгаа. МАН парламентад олонхи болж 60 суудал авсан ч нийт сонгогчдийн 45 хувийн л санал авсан гэдгийг дахиад хэлмээр байна.

### “ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн ээлсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм. Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, бүтээлч чадварыг хөгжүүлнэ. Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдлаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

**Холбоо барих утас: 99094864**

ХААН Банк			Хугалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2240.00	2255.00	ФУНТ	2877.00	2970.00
ЕВРО	2477.00	2544.00	РУБЛЬ	33.40	36.20
ИЕН	21.78	22.33	ЮАНЬ	335.50	338.90

## УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ОРОН, НУТГИЙН СОНГУУЛЬ-2016

Монголын 202, гадаадын 11 иргэнд тавьсан хилийн хоригийг цуцалжээ

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар гадаадын хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан эсэх асуудлыг судалж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулсан байна. Уг ажлын хэсгийг Хууль зүй, Дотоод зэргийн сайд С.Бямбацогт ахалж байгаа аж. Өнгөрсөн хугацаанд ажлын хэсгийнхэн Монгол болон гадаадын иргэдийн гадагш зорчих эрхийг түтгэлзүүлсэн асуудлыг судалж, санал дүгнэлт гаргасан байна. Тодруулбал, хилийн хориг тавигдсан Монгол Улсын 5381, гадаадын 191 нийт 5582 иргэний мэдээллийг ажлын хэсэгт багтсан төрийн байгууллагаас гаргуулж, бүртгэл судалгаатай харьцуулж, судалжээ. Ингэхэд хилийн хориг тавьсан иргэдийн мэдээлэл зөрүүтэй, нэгдсэн бүртгэл байхгүй, зарим мэдээлэл давхардсан байдалтай байгаа юм. Иймд ажлын хэсгээс хилийн хориг тавих, цуцлах үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр мэдээлэл харилцан солилцох журам батлах, хилийн хоригтой иргэдийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах, гэмт хэргийн зүйлчлэл, эрүүгийн хэргийн дугаар, товч агуулга зэргийг тодорхой дурдах, хориг тавьсан болон цуцалсан эсэх саналаа шуурхай мэдэгдэж байх санал гаргажээ. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсгийн мэдээлэлд үндэслэн холбогдох эрх бүхий байгууллагаас Монгол Улсын 202 иргэн, гадаадын 11 нийтгээ 213 иргэнд хилийн хориг тавьсан асуудлыг цуцалжээ.

# Д.ЭРДЭНЭБАТ: ЭНЭ УДАА МАН-ЫН УХРАЛТЫГ ЗОГСООХ ХАРИУЦЛАГТАЙ СОНГУУЛЬ БОЛНО

Үргэлжлэл.  
Түүрүүч нь I нүүрт

Амьдрал бол зөвхөн парламентад өрнөөд байдаг зүйл биш. Харин нийгэмд ард иргэдийн дунд буцалж байдаг. Тиймээс зөвхөн парламентын үнэмлэхгүй олонхоор хүч түрэн асуудалд хандаж болохгүй. Орон нутгийн сонгууль бидний хувьд МАН-ын хийсэн олон ухралтыг зогсоох, ардчиллын төлөөх бусад намууд, иргэний хөдөлгөөнүүд, төрийн бус байгууллагууд нэгдэж энэ ухралтыг зогсоох хариуцлагатай сонгууль ирсэн гэж ойлгож байгаа. Тиймээс АН-ын сонгуулийн штабын гол зорилго үүнд тулгуурлах болно. Орон нутгийн сонгуультай холбоотой эргэлзээ дагуулж буй нэг том асуудал бий. Энэ нь бүртгэл болоод шилжилт хөдөлгөөний асуудал юм. Нэг сонгогч олон газар санал өгөх магадлал өндөр гэдэг маргаан АН-д ирсэн. Тиймээс бид уг асуудалд анхаарч ажиллах болно. УИХ-ын 2016 оны сонгуулиар царцааны нүүдэлтэй холбоотой олон асуудал үүссэн. Үүний маргаантай холбогдуулж УХЦД гомдол үүсгээд явж байна. Би үүгээр юуг хэлэх гээд байна вэ гэхээр орон нутгийн сонгуулиар дээрх хууль зөрчсөн үйлдэл дахин битгий гараасай. АН-ын бүлэг санал оруулж, сонгогчдын шилжилт хөдөлгөөн, бүртгэлтэй холбоотой асуудлаар ажлын хэсэг байгуулах болно. Улмаар Улсын бүртгэлийн газар, ТЕГ-т хандаж 2016 оны сонгуулийн үйл ажиллагаанд дахин шинжилгээ хийлгэх санал тавих юм. Хэрвээ бидэнд ирээд байгаа баримтуудаар нэг сонгогч 2-3 газарт санал өгсөн байвал онц ноцтой гэмт хэрэгт тооцогдох болов уу гэж ойлгож байгаа. Харин энэ үйлдлийг дахин гаргахгүй байх нь АН-ын сонгуулийн штабын гол үүрэг байх болно. Өөрөөр хэлбэл, бид иргэддээ сонголтгүй үнэн зөв хийх ганц боломжийг нь бүрдүүлнэ” гэлээ.

Орон нутгийн сонгуулийн бүртгэлтэй болон нэр дэвшигчтэй холбоотой асуудлаар энэ долоо хоногт аймгийн болон дүүргийн намын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг зохион байгуулахаар болсон байна. Харин УЗХ-ны болон гүйцэтгэх зөвлөлийн гишүүдэд ирэх долоо хоногт орон нутагт ажиллуулахаар илгээх аж. Энэ талаар АН-ын орон нутгийн сонгуулийн менежер Д.Эрдэнэбат “Энэ сонгууль сумдын иргэддээ өнөөдрийн бодит нөхцөл байдлыг мэдрүүлэх, хэлж өгөх, болохгүй байгаа олон ухралтуудыг ойлгуулах сонгууль болно гэж харж байгаа. “Ухралт” гэж энгийнээр хэлж байгаа боловч энэ чинь бидний олон жилийн ардчиллын үр шимээр олсон эдийн засгийн хөгжлийг гацаасан явдал юм. Монгол Улсын эдийн засаг сүүлийн дөрвөн жил бага зэргийн хүндрэлтэй байсан ч бид иргэдээ ажилтай байлгах, бүтээн байгуулалтыг өрнүүлэх гээд олон



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

зүйлийг хийснийг хэн ч үгүйсгэж чадахгүй. МАН-ынханы гэнэтийн нийгэмд өгсөн цочрол нь эдийн засгийн шоконд оруулж, эдийн засгийн огцом агшилтыг өгсөн үйлдэл нь улс орны ирээдүйд асар муугаар нөлөөлөх болно.

АН-ын шинэчлэлийн тухай олон хүн санаагаа члээж байгааг бид ойлгож байгаа. Гэхдээ нэг л зарчим бий. Нэг бүрдсэн чулуун дээрээ хоёр бүдрэх бол ухаантай хүний шинж биш. Тиймээс АН нэг бүрдсэн чулуундаа дахин бүдрэхгүй. АН нээлттэй байсан уу гэвэл нээлттэй байж чадсан. Эрх ашигдаа хөтлөгдсөн бидний алдаан дээр дөрөөлсөн 2016 сонгууль бидэнд сөрөг үр дүнг авчирсан гэдгийг бид ойлгож байгаа. Тиймээс ч бид АН-ын шинэчлэлийн асуудлаар орон нутгийн сонгуулийн үед ч гэсэн орхигдуулахгүй байх болно. 2000 оны арванхоёрдугаар сарын 06-нд АН анх байгуулагдаж байлаа. Одоо харин 16 жилийн дараа буюу 2016 оны арванхоёрдугаар сарын 06-нд бид их хурлаа хийнэ. Ард иргэд АН-ыг шинэ даргатай болоосой хэмээн хүлээж байгаа гэж бид бодохгүй байгаа. Харин АН шинэ бодлоготой, шинэ үйл ажиллагаатай болоосой гэж бид намын шинэчлэлт итгэлтэй байна. Гэхдээ АН-ын шинэчлэл зөвхөн намын шинэчлэл биш байх болно. Өөрөөр хэлбэл, энэ шинэчлэл Монгол Улсын ирээдүйн улс төрийн бодлогын тогтолцооны шинэчлэл байх юм. Их хурлаараа бид намын шинэ дүрмээ батлах учиртай. Тиймээс ч энэ удаагийн сонгуулийн үеэр болон дараа нь шинэ дүрмийнхээ хэлэлцүүлгийг нийт гишүүд, дэмжигчдийнхээ дунд хийх нь зөв гэж үзэж байгаа. Мөн намын даргынхаа асуудлыг ч нийт гишүүд, дэмжигчдийнхээ

дундаас гаргах болно. Шинэчлэл гэдэг бол байнга өсч, дэвшиж байдаг процесс. Тиймээс ч АН-ын шинэчлэлийн ард түмэнд нээлттэй харуулах нь зөв гэж үзэж байгаа.

Мэдээллийг хийсний дараа Д.Эрдэнэбат гишүүн сэтгүүлчдийн асуултад хариуллаа.

“АН-ын шинэчлэлтэй холбоотойгоор залуу гишүүдийн зүгээс намын доторх бүлэг фракц, хэдхэн хүний зөрчлөөс болж УИХ-ын сонгуульд ялагдсан гэсэн шүүмжлэл гаргадаг. Тийм учраас АН задрах, тарах эсэх гэдэг асуудал яригдаж эхэллээ. Та хувьдаа АН дотор үүсээд байгаа асуудлыг юу гэж харж байна вэ?”

“Ардчилсан нам бол ард түмний дундаас буй болсон нам. Үндэсний хэмжээний нам шүү дээ. Нийт иргэдийн маань 35 хувь нь энэ намын дэмжэгч. Тийм учраас эдийн засаг ороулагчийгээр АН задарна, тарна гэдэг ойлголт байхгүй. Фракц гэдэг ойлголтыг эрх ашгийн нэгдэл болгосон нь бидний алдаа байсан. Энэ алдаа 2016 оны УИХ-ын сонгуульд сөргөөр нөлөөлсөн. Бид үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой. Одоо гагцхүү бодлого дээрээ нэг фракц байх ёстой. Би намынхаа залуучуудтай уулзсан. Тэдэнд та нар суманд очоод орон нутгийн сонгуульд оролцоод намын шинэчлэлийн асуудлаар жирийн гишүүд дэмжигчдийн үгийг сонс. Тэрний дараа ахиад хэдүүлээ асуудлаа ярьж гэж хэлсэн. АН гэдэг бол нэг хэсэг хүмүүсийн хэлснээр задардаг нам биш гэдгийг хаа хаанаа хатуу ойлгох хэрэгтэй.

“Үндсэн дүрмийн шинэчлэл

хийнэ гэлээ. Намын дүрмийг шинэчлэх асуудлаар ажиллаж байгаа юм уу?”

“Намын дүрмийг шинэчлэх төслийг зургаан жилийн өмнө хийсэн. Үүнийг хоёр удаа орон нутгийн намын байгууллагуудаар хэлэлцүүлсэн дүрмийн төсөл байгаа. Өнөөдөр Хэрэг эрхлэх газар дээр ажлын хэсэг ажиллаж байна гэж ярьдаг. Харин сайнаар хуралдаанаараа яг их хуралдаа оруулах үндсэн дүрмийн шинэчлэлийн ажлын хэсгээ байгуулахаар төлөвлөж байгаа.

“Дүрмийн асуудлыг УЗХ-гоор оруулна гэж байна. Гэтэл танаа намын гишүүд УЗХ-гоо эрх зүйн чадамжгүй фракцид хуваагдсан гэдэг шүү дээ?”

“Үндсэн дүрмийг өнөөгийн УЗХ батлахгүй. Энэ асуудалд итгэлтэй байж болно. УЗХ Үндсэн дүрмийн шинэчлэлийн ажлын хэсгээ байгуулна. Энэ ажлын хэсэг ажиллаад арванхоёрдугаар сарын 06-нд үндсэн дүрмээ Их хурлаараа батлахад хуучин УЗХ өөрөө шинэ дүрмийнхээ хүрээнд татан буугдана. Бид бүх зүйлийг цорын ганц үйлдэл гэж үзжээ. Тэр бүртгэл манай намын сонгуультай холбоотой дотоод асуудал яригдаж байсан. Гэхдээ яриа нь буруу биш. Ямар байж байгаад сонгуулийн тогтолцоо өөрчлөгдсөн гэдгийг манай намынхан нийтээрээ мэдэж л байсан. Харин өнөөдөр нийгэм мэдэж байх шүү байна.

МЭДЭЭЛЭЛ

## Энхийг сахиулагчдыг төрийн одон, медалиар шагнав



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд олон улсын Энхийг сахиулагчдын өдрийг тэмдэглэв. Уг арга хэмжээний үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн хурандаа Б.Баатар захиралтай V ээлжийн мотобуудлагын батальон, Бүгд Найрамдах Судан Улсын Дарфур мужид явуулж буй Африкийн холбоо, НҮБ-ын хамтарсан энхийг сахиулах “UNAMID” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн дэд хурандаа Г.Тунгаамаа захиралтай цэргийн хэргийн хоёрдугаар шатны эмнэлгийн VI ээлжийн бие бүрэлдэхүүнд төрийн одон, медаль гардуулах

ёслол боллоо. Энхийг сахиулагч дайчдын шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан гардуулан өгсөн юм. Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор хурандаа Б.Баатар, хурандаа Ж.Мөнхтөр нарыг, Цэргийн гавьяаны одонгоор дэд хурандаа Г.Тунгаамаа, дэд хурандаа Ж.Сүх-Очир, Н.Баасан, хошууч Р.Баянмөнх, дэд хурандаа Э.Мөнх-Оргил, С.Батбуян нарыг, Цэргийн хүндэт медалиар ахлах ахлагч Г.Сарандаваа, О.Уламбаяр, Г.Мөнхбат, Б.Пүрэвсүрэн, Д.Нэргүй, Б.Жаргалсайхан, С.Чинбат нарын зэрэг хүмүүсийг шагнала. Бусад дайчдыг энхийн төлөө медалиар шагнасан юм.



## Эмэгтэй гишүүдийн айлчлал нэртэй “зугаалга” тасрахгүй нь

Ж.МЯГМАР

МАН-ынхан үнэмлэхүй олонхи болсныхоо хэрээр ёстой л нэг дураараа дургиж, дунд чөмгөөр нь жиргэж байна. Түүгээр ч барахгүй УИХ-ын гишүүд хэмнэлтийг өөрсдөөсөө эхлүүлнэ, зардлаа танаа гээд л хэсэг ярьсан. Гэвч тэд хэлсэн амлалтаа хүрдэг хүмүүс үү, үгүй юу гэдэг нь одоо харагдаж эхлээд байна даа. Ганцхан жишээ дурдахад л, өнөөх хатан ухаанаар төр удирдаж, “МАНдуулина” хэмээн бахархаад байсан эмэгтэй гишүүд маань гадаад, дотоодод аялж, галуу шувууны мах идээд зугаалаастай. Онцлоод хэлбэл, МАН-ын зургаан эмэгтэй гишүүн БНСУ-ын парламентын гишүүн Ким Ён Жүний урилгаар тус улсад айлчлал нэртэй “амралт зугаалга” хийгээд завгүй явна. Уг нь

өнгөрсөн парламент одоо байгаагаас цөөн буюу 11 эмэгтэй гишүүн байсан. Гэхдээ тэд санаа нэгтгэйгээр хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой олон асуудлыг шийдэж чаддаг байлаа. Харин энэ удаагийн парламент бүр олон буюу 13 эмэгтэй гишүүнтэй болсон. Гэтэл тэдний дуу хоолой яг хэрэгтэй үед гарахгүй байгаа нь хачирхалтай. Харин ч энэ үеэр айлчлал нэртэй аялал зугаалга хийгээд түүнийгээ баталгаажуулан патнаараа татуулсан шигээ цахим ертөнцөөр “гангарч” байх юм. Хямрал дээд цэгтээ тулж байхад эд нар хэний мөнгөөр явж байгааг шалгах хэрэгтэй бус уу. Нөгөө хэмээлт энэ тэр хаа байна вэ. Хүчирхийллийн эсрэг хуулийг хойшлуулж, хайран сайхан залуу бүсгүйчүүд бэлд нөхрийнхөө гарт амь үрэгдэж байхад тэд зугаалж явна. Гутамшигтай юм даа.

**MINFO**

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлаланы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцияд эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



ҮЗЭЛ БОДОЛ

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Бондын арилжааны хүрээнд 12 долоо хоног буюу гурван сарын хугацаатай, жилийн 15.7 хувийн хүүтэй 50 мянган ширхэг үнэн цаас гаргаж, таван тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн аж. Мөн 28 долоо хоног буюу зургаан сарын хугацаатай, жилийн 16.4 хувийн хүүтэй үнэт цаас борлуулж, 10 тэрбум төгрөг зах зээлээс татах аж. Мэдээж үнэ өртөг нь ч тодорхой болчихсон. Ингээд л Засгийн газар төсвийн алдагдлаа нөхөхийн тулд банкуудад байгаа мөнгийг зээлж аваад, иргэд л хөөрхий болж үлдэх нь. 15 тэрбум төгрөг гэдэг Засгийн газрын хувьд

эхэлсэн. Хугацааг нь багасгаж, зээл өгөх хэмжээгээ ч танасан. Ядаж байхад эдийн засаг хямрахын хэрээр банкны секторын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдээд байгаа. Одоогоор нэг их наяд төгрөгийн чанаргүй зээл үүсчихсэн гэсэн. Энэ нь нийт зээлийн 8.6 хувийг эзэлж байгаа аж. Чанаргүй зээлийн эзлэх хувь ч 2013 оны хоёрдугаар улирлаас хойш тасралтгүй нэмэгджээ. 2009 онд эдийн засаг хямрахад чанаргүй зээлийн хэмжээ 17.4 хувь хүрч байсныг эс тооцвол гайгүй байна. Гэхдээ л өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлаас даруй 1.5 хувиар өсчихөөд байгаа юм. Энэ нь ч гэсэн банкууд зээлээ хумихад нөлөөлж байгаа. Ийм хүнд үед Засгийн газар дотоодоосоо 15 тэрбум төгрөг босгохоор

## ЗАСГИЙН ГАЗАР БАНКНЫ СЕКТОРЫН МӨНГИЙГ ХАМЖ, ИРГЭДЭД ЗЭЭЛ ОЛДОХГҮЙ БОЛОХ НЬ

бага л байх. Төсвийн алдагдлыг их наядар ярьж байхад. Харин банкны салбараас энэ хэмжээний мөнгө гараад явчихвал юу болох билээ. Гараад явчихвал гээд байх юмгүй, гарна. Өнөөдөр банкууд найдвартай зээлдэгч хайгаад, бүх зээлээ бараг хаачихаад байгаа. Үнэндээ бол зээл өгнө гэж байгаа шалгуураа өндөрсгөхөөр хэн ч зээл авч чадахгүй байгаа. Ялангуяа орон сууц авах гэсэн иргэд. Энэ үед Засгийн газар бонд гаргахаар банкууд авах нь гарцаагүй. Эрсдэл багатай, хүү өндөртэй зээл. Ингээд л банкны сектороос 15 тэрбум гараад явчихаар тэртээ тэргүй иргэд, аж ахуйн нэгжид олгохгүй шахуу байгаа зээл чинь улам л ховрын бараа болно биз дээ. Засгийн газар ийм л буруу алхам хийлээ.

бонд гаргаж байгаа нь ёстой арга барсан арчаагүй үйлдэл. Нэгэнт ингэглээ зэлээ хумьчихсан банкууд одоо Засгийн газрын бондыг авчихаад, эрсдэлгүй сайхан зээл өглөө гээд сууж байна. Хэрвээ банкны секторт зээл маягаа өгөх бага сага мөнгө үлдвэл зээлийн шалгуураа дахиад нэмэгдэнэ. Сарын сая төгрөгийн цалинтай хүнд 500 мянган төгрөгийг жилийн хугацаатай зээлэх гэж “луу унжих” байх даа, хөөрхий.

**Дотоодоосоо биш гадаадаас...**

Уг нь Засгийн газар дотоодынхоо банкинд байгаа хэдэн төгрөгийг зээлж аваад, иргэдээ “хамраар нь хатуулах”-ын оронд гадаад зах зээлээс татах бодлого барих ёстой байсан. Тэгж чадвал нөхцөл байдал арай дээрдэнэ. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурчихсан, эхний зээлийн эргэн төлөлтөө хийх чадваргүй байхад манайд мөнгө өгөх гадны хөрөнгө оруулагч гэж байхгүй л гэх байх. Гэтэл Засгийн газар төсөв мөнгөний бодлогоо цэгцлээд, сахилга баттай болгочихвол мөнгө өгөх гадны хөрөнгө оруулагчид зөндөө л байгаа. Үүнийг би биш мэдэх хүмүүс нь хэлж байна. Гэтэл Засгийн газар яав, ердөө л орон нутгийн сонгуулийн үр дүнд л анхаарлаа хандуулж байгаа. Юун төсөв хэмнэж, сахилга баттай болгох.

Харин ч байгаа хэдээ орон нутгийн сонгуулийн өмнө тараахад ч бэлэн байх шиг байна. Ийм байвал яаж өөдлөх вэ дээ. Зарим эдийн засагчид, тоймчид Засгийн газар “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах нь тодорхой гээд байгаа. Үнэхээр тийм л юм бол хурдхан хамрагдчихаач ээ. Улс орны эдийн засаг дээшилж, тогтож байвал тэр орон нутгийн сонгууль энэ тэр чинь лөөлөө байна, эрх баригчид аа. Хурдхан “Стэнд бай” хөтөлбөртөө хамрагдаад, төсвийн замбараагүй байдлаа цэгцлээд өгвөл гадны хөрөнгө оруулагчид биднийг арай өөр нүдээр харах байх. Тэгээд “хэрүүлийн алим” болсон “хоёр” толгойгоо хөдөлгөөд, энэ улс орноо авармаар байна.

**Зээлийн жилийн өсөлт хасах руу орчихсон, одоо...**

Монголбанкнаас гаргасан тоон мэдээллийг иш татъя. 2016 онд гараад банкууд нийт зээлийнхээ 37.5 хувь буюу ихэнхийг нь хэрэглээний зээл маягаар өгсөн байна. Харин худалдааны чиглэлд нийт зээлийн 22.7 хувийг өгч. Уул уурхай, барилга гээд томоохон салбарт бараг зээл өгөөгүй. Эдийн засаг тэлж байсан 2013 оны дөрөв, 2014 оны нэгдүгээр улиралд хэрэглээний зээл 60 хувиар өсч байж. Барилгын салбарт өгсөн зээл гэхэд 2014 оны нэгдүгээр улиралд 30 орчим хувиар өссөн байдаг. Уул уурхай ч ялгаагүй, 50 орчим хувиар өссөн. Худалдааны салбарын зээлийн өсөлт 40 хувьд хүрч байжээ. Харин түүнээс хойш тасралтгүй буурсаар, өнөөдрийн байдлаар бүхий л салбарт зээлийн өсөлт хасах руу орчихлоо. 2016 оны нэг, хоёрдугаар улиралд ипотека, худалдаа, хэрэглээний зээл л нэмэхтэй байна. Бусад нь бүгд хасах руу орчихсон. Ерөнхийдөө бараг л бүх салбарт багахан хэмжээний л зээл олгож байна. Өөрөөр хэлбэл, банкны маш өндөр шалгуурыг давсан цөөн аж ахуйн нэгж, иргэнд л зээл олгож байна гэсэн үг. Өмнө нь цалингийн зээл олгохдоо урт хугацаанд, ахиу мөнгө өгдөг байлаа, банкууд. Гэтэл 2016 оны эхний улирлаас эхлээд илт танаад

Дугаарын **60** мөр

## Анагаах ухаан хөгжөөд байхад аспирын, цитрамоноо хэрэглэсээр л байх уу

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Ер нь манайхан эмчид үзүүлэхдээ аль хэдийн өөрөө өөрсдийгөө оношилж, бүр зарим тохиолдолд дур мэдэн эмчлэх нь бий. Тархиар хатгавал цитрамон уучихна. Гэдэс рүү өвдвөл левоминин, хэвлийгээр өвдвөл ношпа, хүүхдийн чихээр хатгавал парацетамол таллаад уулгачихна. Ханиад хүрвэл халуун аарц, чацаргана ууж, бүр эдгэрэхгүй бол антибиотек уугаад л нам дарчихна. Тэр бүр эмч рүү гүйж сүйд болохгүй. Үзүүлье гэсэн ч, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж муу, өрхийн эмч нь ч өнөөх л эмийг нь бичнэ. Ийм зүйлд цаг алдахын оронд өөрт ойр байрлах эмийн санд очоод хэрэгтэй эмээ авах нь илүү амар байж болох. Эмийн санчид ч эмчээс дутахгүй зөвлөгөө өгч, ямар нэг эмчийн жор шаардахгүйгээр бизнесээ эрхэлчихнэ. Ерөнхийдөө манай орон гурван сая хүн амтай гэж тооцвол насанд хүрсэн 1.8 сая орчим хүн бий. Тэгэхээр төд орчим “сайн дурын эмч” өөрийгөө болон өрөөлийг

эмчилж байна гээд хэлчихвэл хэтийдсэн болохгүй. Эмийн сангийн тоо ч борооны дараах мөөг шиг олширчээ. Нэг хорооны нэг өрхийн эмнэлэгт дөрвөн эмч ажилладаг гэж бодвол түүнээс хэд дахин олон эмийн сан тус хороонд ажиллаж, иргэдийг эмчилж байх жишээтэй. Нөгөө талаар, социал медиа эрчимтэй хөгжиж буй өнөө үед аль нэг группт элсээд л юу өвдөхөд ямар эм уух талаар мэдээллийг авч болж байна. Энд ээжүүдийн группийг дурьдаж болох бөгөөд гэртээ хүүхдээ хардаг эхчүүд нэгэн группт нэгдэж, бие биедээ зөвлөгөө өгч өнөөх л эмийн хэрэглээг сурталчилна. Дурын нэгэн компани фэйсбүүк, твиттер сүлжээ ашиглан эмээ сурталчилж, бүр хүргэж өгч үйлчлэхийг нь яана. Ийм бизнес цэцэглэж байгаа нь худалдан авагч байгаагийн нэг жишээ биш гэж үү. Үүнээс гадна айл бүр эмийн сантай. Гэхдээ өнөөх л түгээмэл хэрэглэгддэг 1877 оноос анагаах ухаанд хэрэглэгдэж эхэлсэн парацетамол, ижил үйлдэлтэй анальгин, цитрамон, аспирын байсан хэвээр.

Хүн амд ногдох эмнэлгийн үйлчилгээний чанар тааруу, хүрэлцээ муугаас иргэд эмийн компаниудын рекламны заавраар элдэв эм хэрэглэхийг илүүд үзэх болсон нь ч нууц биш. Иймээс монголчууд аль хэдийнэ эмийн зохисгүй хэрэглээнд лав шигджээ. Дэлхийн анагаах ухаан хоног тутам хөгжиж, өдөр бүр шинэ эм туршигдан баталгаажиж өмнө нь эмчилгээгүй гэгдэж байсан өвчин өнөөдөр эмчлэгддэг болж байна. Хэдэн зууныг элээсэн эмээс хэд дахин үйлчилгээтэй сайн чанарын эмүүд үйлдвэрлэгдэн эмчилгээнд нэвтэрч байхад Монголд өрхийн эмч хийгээд өнөөх “зөвлөн үзсэн чавганц”-уудын мэдлэг яг ижил төвшинд байсан байгаа нь эмийг хоол шиг хэрэглэхэд нөлөөлж байгаа бус уу. Арга ч үгүй биз дээ. Их сургуулийн ширээнээс дөнгөж гарсан шинэхэн төгсөгчид өрхийн эмнэлэгт ажилладаг хойно, яалтай ч билээ. Гэхдээ ийм байдалд дасан зохилтоо гараа хумихад суух бус, эрин үетэйгээ хөл нийлүүлж, чадвартай эмчийн жороор өвчнөө илааршуулахсан, сайд аа.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **64** дугаар

**Захиалгын үнэ 18000**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

# ДЭЛХИЙ



## БНАСАУ

# ПУУЖИНГИЙН ХӨДӨЛГҮҮР ТУРШЛАА

Б.ДАВАА

БНАСАУ өчигдөр өглөө шинэ загварын өндөр хүчин чадалтай пуужингийн хөдөлгүүр туршиж, туршилт нь амжилттай болсон талаар тус улсын төрийн мэдлийн агентлаг уламжиллаа. Энэхүү туршилт амжилттай болсноор БНАСАУ бүх төрлийн хиймэл дагуул хөөргөх боломжтой болж байгаа юм. Тус улсын залуу удирдагч Ким Жон Ун ч эрх баригч Хөдөлмөрийн намын хурал дээр энэ талаар мөн мэдээлжээ. Пхеньяны зүгээс шинэ загварын пуужингийн хөдөлгүүрийг хиймэл дагуул хөөргөхөд гарсан дэвшил хэмээн дамжуулж байгаа. Гэвч Сөүл, Вашингтоны тал хиймэл дагуул нэрийн дор холын тусгалт баллистик пуужингийн хөдөлгүүрийн туршилтыг хийсэн байх магадлалтай хэмээн хардаж байна. Залуу удирдагч Ким туршилтын зорилгын талаар “Шаталтын онцлог, хяналтын системийн хэвийн ажиллагаа зэргийг хамгийн сүүлийн байдлаар бататгах зорилгоор туршилт хийсэн” гэх тайлбар хийжээ.

...Пхеньяны зүгээс шинэ загварын пуужингийн хөдөлгүүрийг хиймэл дагуул хөөргөхөд гарсан дэвшил хэмээн дамжуулж байгаа. Гэвч Сөүл, Вашингтоны тал хиймэл дагуул нэрийн дор холын тусгалт баллистик пуужингийн хөдөлгүүрийн туршилтыг хийсэн байх магадлалтай хэмээн хардаж байна...

Мөн туршилт амжилттай болсны дараа хиймэл дагуул хөөргөх бэлтгэл ажлыг яаралтай зохион байгуулахыг даалгасан байна. Пхеньян энэ

сарын 9-нд тав дахь удаагийн мэдээлэл зэвсгээ туршсан. Улмаар үүнтэй холбоотойгоор Сөүл дайны бэлэн байдалд шилжиж, АНУ стратегийн бөмбөгдөгч онгоцоо илгээсэн юм.

Мөн Японы Өөрийгөө хамгаалах цэргийн хүчин ч БНСУ-д дэмжлэг үзүүлнэ гэдгээ илэрхийлсэн билээ. Тав дахь удаагийн цөмийн туршилт хийсний дараа Пхеньян баллистик пуужинд цөмийн цэнэгт хошуу байрлуулах боломжтой болсноо зарласан байдаг. Харин энэ удаа шинэ загварын өндөр технологийн пуужингийн хөдөлгүүртэй болсноо зарласан нь олон улсын анхаарлыг татаж эхэллээ. Үүнээс гадна Хөдөлмөрийн намын төв хэвлэлд гарсан зурагт өнгөрсөн дөрөвдүгээр сард болсон ICBM загварын тив хоорондын баллистик пуужингийн туршилттай яг адил дүр зураг дүрслэгдсэн байна. Харин хажууд нь Ким цэргийнхнийхээ хамт нэгэн зогсож буй байдал хэвлэлийн хуудаснаа гарчээ. Үүний хариуд БНСУ-ын Баглан хамгаалах яам мэдэгдэл хийсэн

бөгөөд “Пхеньяны талын мэдээлэл үнэн бол тэдний пуужингийн хөдөлгүүрийнх нь хүчин чадал дээшилсэн гэсэн үг. Туршилт үнэхээр амжилттай болсон эсэхийг шалгаж тогтоох шаардлагатай” гэжээ. БНАСАУ-д ирэх сарын 10-нд Хөдөлмөрийн нам байгуулагдсаны 71 жилийн ой болох юм. Ямартай ч, дэлхийн хамгийн хаалттай орны дарангуйлагч Ким энэ удаа шинэ загварын хөдөлгүүрийг туршсан нь хиймэл дагуул, эсвэл холын тусгалт пуужинд зориулагдсан уу гэдэг нь одоогоор тодорхойгүй байна.

## Сүйрсэн хөлгөөс 2000 жилийн өмнөх хүний яс олдлоо

Археологийн судалгааны баг газар дундын тэнгист живсэн хөлөг онгоцноос 2000 жилийн өмнө манай дэлхийд амьдарч байсан хүний арга ясыг олжээ. Энэ талаар Их Британийн “Nature” сэтгүүлд мэдээлсэн байна. Эдүгээ ч шинжлэх ухаан учрыг нь тайлж чадаагүй Антикитерийн механизмг олсон Грекийн Антикитер арлын ойролцоогоо живсэн хөлгөөс уг арга ясыг өнгөрсөн сарын 31-нд олжээ.

Олдворт гавлын ясны хэлтэрхий, гарны яс, хавирга, хөлний хэсгийн яс багтаж буй бөгөөд эдүгээ учир нь тайлагдаагүй алдарт МЭӨ нэгдүгээр зууны үеийн хөлөг онгоцны нууцыг тайлахад нэмэр болохыг судлаачид онцолсон байна. Мөн ясанд ДНК-ын шинжилгээ хийхээр Грекийн Засгийн газраас зөвшөөрөл хүсчээ. Живсэн хөлгөөс хүний арга яс олдсон тохиолдол маш ховор байдаг юм байна. Учир нь далайн усанд урсах, аварга загсанд идүүлэх гэх мэт шалтгааны улмаас бүтэн үлдсэн эртний хүний яс тэр бүр олддог байдаггүй байжээ. Араг ясанд генийн шинжилгээ хийснээр үс, арьсны өнгө, уг гарвалыг нь тодорхойлох боломжтой болох юм байна.

## Киргизын Ерөнхийлөгч ээлжийн амралтаа авчээ

Киргиз улсын Ерөнхийлөгч Алмазбек Атамбек эмнэлгийн нарийн шинжилгээнд орох болсон тул богино хугацааны ээлжийн амралт авчээ. Ерөнхийлөгчийн хэвлэлийн албанаас мэдээлснийг үзвэл “Ерөнхийлөгч богино хугацааны амралт авсан нь эмнэлгийн нарийн шинжилгээнд орох болсонтой холбоотой, түүний эрүүл мэндийн байдлын тухайд санаа зовох зүйл байхгүй” гэсэн байна. Ерөнхийлөгч ирэх сарын 1-ний өдөр ажилдаа эргэн орох бололтой. Эрүүл мэндийн байдалтай холбоотой асуудал гарсан учраас Атамбаев Нью-Йоркт хийх гэж байсан ажлын айлчлалаа цуцалсан юм. Тэрбээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн

чуулганы ерөнхий хэлэлцүүлэгт оролцох ёстой байжээ. Истанбул хотын Ататюркийн нэрэмжит олон улсын нисэх онгоцны буудлаар дамжин Нью-Йорк руу нисэх гэж байсан Атамбаевын бие гэнэт тавгүйрсэн байна. Тэр даруй нисэх онгоцны буудалд эмнэлгийн нарийн шинжилгээ хийхэд “зүрхний үйл ажиллагаатай холбоотой хүндрэлийн шинж тэмдгүүд” илэрчээ. Ийм учраас илүү нарийн шинжилгээ хийлгэхийг Туркийн эмч нар зөвлөсөн байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганд оролцож буй Киргизийн төлөөлөгчдийг тус улсын Гадаад хэргийн сайд Эрлан Абдылдаев тэргүүлж байна.

## Жим Кэрри хүн амины хэрэгт сэжиглэгдэв

Холливудын чадварлаг жүжигчдийн нэг, инээдмийн киноны мастер гэгддэг жүжигчин Жим Кэрри өнгөрсөн жил нас барсан экс найз бүсгүй Катриона Вайтын үхэлд сэжиглэгдэн шүүхэд дуудагджээ. Калифорни мужийн Лос Анжелес хотын шүүхэд тэрбээр дуудагдсан бөгөөд талийгаач Вайтын салсан нөхөр Марк Буртон түүнийг ийнхүү буруутган нэхэмжлэл гаргасан аж. Марк Буртоны хэлснээр Жим нууц нэрээр бүсгүйд эм нийлүүлж байсан гэнэ.

Тэрбээр нэхэмжлэлдээ “Жим эд баялаг, алдар нэр, байр сууриа ашиглан “Артур хаан” гэх хуурамч нэрээр Вайтад эм нийлүүлж байсан. Гэвч Вайтыг нас барсны дараа өөрийнхөө оролцоог нууж, хариуцлагаас мултарсан” хэмээн онцолжээ. Мөрдөн байцаагчдын хэлж буйгаар бүсгүй “ambient”, “prog-anolol” болон “percocet” гэх эмнийг хэтрүүлэн хэрэглэсний улмаас амиа алдсан байна. Харин түүний цогцыг олох үед хажууд нь “Артур хаан” гэх нэр бичсэн гурван ширхэг эмний лонх байжээ.

## Нигерийн Ерөнхийлөгч Обамагийн үгнээс “хулгайлжээ”

Нигерийн Ерөнхийлөгч Мухаммаду Бухари саяхан тавьсан нэгэн илтгэлдээ “Өөрчлөлт надаас эхэлнэ” гэх үгийг дурьдаад шүүмжлэлд өртжээ. Учир нь түүний дурьдсан энэ үгийг АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама 2008 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ялалтаа зарлах мөчдөө хэлж байжээ. Харин түүний хэлсэн үгийг Бухари Ерөнхийлөгч дурьдсанаар “үг хулгайлсан” гэх шүүмжлэлд өртсөн байна. Тэрбээр 1980-аад оноос хойш цэргийн дэлгэмийг тэргүүлж, “Хууль зөрчигсдийн эсрэг” тэмцлээ үргэлжлүүлж буй бөгөөд энэ сарын 8-нд Нигерт хээл хахуулийг устгах кампанит ажил өрнүүлж эхэлсэн юм. Энэхүү ажиллагааны нээлт Абужа хотод болжээ. Тэрбээр энэ үеэр “Өөрийгөө хэр өөрчлөгдсөнийг эхлээд өөрөөсөө асуу” гэж хэлсэн байна. Харин үүний дараа Нигерийн Ерөнхийлөгчийн ордон Бухари Ерөнхийлөгчийн илтгэлийн зарим хэсэг АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн хэлсэн үгнээс санаа авсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийжээ. Харин үүнийг Ерөнхийлөгч Бухари өөрөө үгүйсгэж, эдүгээ маргаан мэтгэлцээний сэдэв болж хувирчээ.

## Эсэргүүцлийн жагсаалын үеэр 50 гаруй хүн нас барлаа

Бүгд найрамдах Ардчилсан Конго улсын нийслэл Киншаса хотод тус улсын Ерөнхийлөгч Иосеф Кабилаг огцрохыг шаардсан эсэргүүцлийн жагсаал зохион

байгуулагджээ. Улмаар жагсагчид аюулгүйн албаныхантай мөргөлдсөний улмаас 50 гаруй хүн амиа алдсан байна. Энэ явдалтай холбогдуулан улс даяар томоохон хэмжээний жагсаал хийхийг уриалж байсан сөрөг хүчин ч, цаашид Засгийн газрын эсэргүүцсэн жагсаалыг өргөн хүрээнд зохион байгуулахыг уриалжээ. Тэд “Жагсагчдын 50 гаруй нь нас барсан. Цагдаа нар, аюулгүйн албаныхан тэдэн рүү гал нээж, ийм олон хүний аминд



хүрсэнд харамсаж байна. Шаардлагаа биелүүлэхийн тулд цаашид ч эсэргүүцлийн хөдөлгөөнө үргэлжлүүлнэ” хэмээн хэвлэлийнхэнд ярьсан байна. Иосеф Кабилагийн бүрэн эрхийн хугацаа хэдийгээр дууссан ч, хууль зөрчин Ерөнхийлөгчийн албыг хаших хугацааг сунгасныг жагсагчид эсэргүүцэж байгаа аж.

MMINFO.

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

Манай сайт апплейшнтэй боллоо

MMINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAХ PLAY STORE

TATAХ APP STORE

# УЛС ТӨР

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зургийг Т.АРИУУЖИН

Т.ДАВААНИАМ

*Ардчилсан Намын /АН/ шинэчлэлийн талаар болон бусад асуудлаар АН-ын ҮЗХ-ны гишүүн, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга асан Пунцагийн Цагаантай ярилцлаа.*

**-АН-ыг шинэчлэх ҮЗХ-ны хурлын асуудлаар сүүлийн үеийн сонин сайхан юу байна вэ?**

-Их л зүйл өрнөж байна даа. **-Тодруулбал?**

-Монголын ард түмний 1990 оны түүхэн сонголтгүй зорсон үр дүнд нь хүргэх улс төрийн хүчин нь АН байгаагаар гэж олон түмэн боддог, итгэдэг. АН-ыг шинэчлэхийг АН-ын гишүүд, ард иргэд ярьж, шаардаж байна. ҮЗХ-ны хурлаа хийж, алдаа оноогоо тайван ярьж хэлэлцэе гээд гишүүд цуглачихаад байхад бас нэг шалтгаан олоод ҮЗХ-ны хуралдааныг дахиад л хойшлуулчихлаа. Үүнд олон хүн бухимдаж, зарчмын шүүмжлэл хэлж байгаа.

**-АН-ын шинэчлэлийг хүлээн хүмүүс их байна. Бас МАН-д итгэл алдарсан хүмүүс ч олширч байна. Хоёр гол нам нь ийм урагшгүй болчихоор нийгэм маань яах болж байна?**

-Монгол Улсыг том зургаар харвал, өнөөдрийн нийгэмд хуримтлагдсан хүндрэл, хүлээлт, бухимдал бол зөвхөн АН-ыг шинэчлэх асуудлаар хязгаарлагдах биш юм байна гэдэг нь улам тод харагдаж байна. Монголын нийгэм, эдийн засагт ихээхэн гажуудал үүсчхэсэн байна. Энэ гажуудлыг засахын тулд АН өөрөө эхлээд шинэчлэгдчихвэл үндэсний эрх ашигт илүү нийцнэ гэж боддог. Монголын нийгэм дэх гажуудал архагшиж, бас булгаж, бүгшнх шинэжтэй болж байна. Түүний нэг илрэл нь л сонгуулиар амласныхаа яг эсрэг зүйл хийж байгаа эрх баригчдад иргэдийн итгэх итгэл богино хугацаанд алдарч байгаа явдал. Хамгийн уршигтай үр дагавартай нь үндэсний баялаг бүтээгчид төр засгаасаа эмээсэн, хүлээгдсэн, үйлчилгээнд нь итгэхгүй, аргаа бараад төрийн алба рүү хошуурч байна. Зүй нь тэд маань эх орондоо тайван амар баялаг бүтээж байвал өөрт нь ч, нийгэмд ч хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулагчид ч итгэхгүй, дүрвэж байгаа тухай барууны хэвлэлд их тод бичиж байна. Нэг л болж өгөхгүй байна. Ер нь бол төрийн хууль алагчлалгүй, жигд, тогтвортой мөрдөгдөх зарчим алдагдаад эхлэхээр төрийн нэр хүнд ч, ажил нь ч унадаг. Энэ бол дэлхийн аль ч оронд үйлчилдэг түгээмэл хууль.

**-Хууль тогтвортой тууштай мөрдөгдөхгүй байгааг та жишээтэй ярьж болох уу?**

-Бололгүй яах вэ. Энгийн жишээ. Шинэ Засгийн газар байгуулагдах бүрт яамдын нэр өөрчлөхөд л ямар их муу үр дагавартайг ухаарах цаг болсон. Хууль зөрчихгүйгээр гэж боддог боловч, үнэндээ хууль зөрчин байж хэдэн хүн халахын тулд, аль эсвэл хэдэн хүнийг ажилтай болгохын тулд сонгууль болгоны дараа төр засгийнхаа бүтцийг бүжигнүүлж байх юм. Монгол гэдэг чинь дэлхийн 200 гаруй айлын нэг. Нэг айл нь байсхийгээд л хүүхдүүдийнхээ нэрийг солиод, төрсний шинэ гэрчилгээ, иргэний үнэмлэх аваад байвал хажуу айл нь битгий хэл тухайн айлын аав, ээж нь хүртэл будилж гүйцнэ биз дээ. Одоо ч дэлхий гайхахаа больсон. Зүгээр л өрөвдсөн нүдээр хардаг болсон, биднийг. Гадаадын нэг том хөрөнгө оруулагч уулзаад, жил гаруй хэлэлцээ хийгээд гэрээнд гарын үсэг зурах гээд иргэл сайд нь огцорчихсон гэв. Сайд огцорч болохгүй яах вэ, яаман дээр очиж, шинэ сайдтай нь уулзаж гэтэл яам нь татан буугдаад алга болчихсон гэв... Ингэж болдог юм уу? гээд толгой сэгсэрч байсан.

**-Төр засгийн бүтэц тогтвортой, төрийн алба мэргэшсэн байна гэдэг хоосон уриа лоозон болж хувирлаа. Төр засгийг гөвхнүүлдэг гол хууль болох сонгуулийн хууль нь сонгууль болгоны өмнө өөрчлөгддөг, тэгээд ч бүрэн мөрдөгддөг. Улс төрийн намын хуулийн хэрэгжилтийг хар. Үндсэн хуулиар 25 жилийн өмнө нам төвтэй улс төрийн тогтолцооноос төр төвтэй улс төрийн тогтолцоо руу шилжинэ гэсэн. Гэтэл нам өнөөдөр ч төрийг зайдангасар, сулруулсаар л байна. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог салбарынхны шинэчлэл олигтой хийгдээгүй, хийсэн заримыг нь булшилчихсан учраас Монголын төрийн эрх мэдлийн хуваарилалт, харилцан хяналт тавих зарчим гурав биш, хоёр хөл дээрээ тогтож ядан догонцож байна.**

**-Та саяхныг хүртэл төрийн том алба хашиж байсан. Өөрөө тэдгээр шинэчлэлийг хийж болохгүй юм уу?**

-Бид хуулийн засаглалтай улс байх замыг сонгосон. Тийм болохоор өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч маш олон хуулийн төсөл санаачилж, УИХ-д өргөн барьсан. Сүүлдээ манай УИХ-ын зарим гишүүд Ерөнхийлөгч хэтэрхий идэвхтэй байна, хууль санаачлах эрхийг нь Үндсэн хуулиас хасья гээд явж байсныг хүмүүс санаж байгаа байх. Би Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх болоод Шүүх эрх мэдлийн

залварын шинэтгэлийг эхлүүлэхэд ханцуй шамлан оролцсон гэдгээ нүүр бардам хэлнэ. Ганц жишээ хэлэхэд, шүүхийн шийдвэрийг ил болгомогц л шүүхийн шийдвэрийн чанар, тэр бүү хэл хэл бичгийн найруулга, зөв бичгийн дүрэм нь хүртэл сайжирч, шүүхийн талаархи иргэдийн гомдол эрс буурсан. Зарим шинэтгэл ойлголтын зөрүү, хувь хүмүүсийн хоорондын харилцаа, зөрчил зэргээс улбаалж бүдэрсэн, дутуу дулимаг хийгдсэн, бүр ухарсан зүйл ч бий... Миний хувьд, бусдад ойлгуулах, бусдаар хийлгүүлэх буюу шийдүүлэх гэж их оролдсон, хичээсэн. Бухимдах тохиолдол ч олон байсан. Ер нь аливаа шинэтгэлийг түүний зайлшгүйг ойлгосон, мэдэрсэн хүн л хийдэг юм байна. Энэ байдал ч намын, улс төрийн шинэтгэлийн ажлыг сонгоход надад нөлөөлснийг нуугаад яах вэ.

**-Тэгээд яах вэ. Гарц нь?**

-Шуудхан хэлэхэд, Үндсэн хуулийн шинэтгэл хийж, монгол төрийн тогтвортой байдал, залгамж шинж, чадавхи, алсын хараа, түүнд тавих ард түмний хяналт, оролцоо, хууль, шударга ёс, шүүх эрх мэдэл, улс төрийн намуудын тогтолцоо зэрэг олон асуудлыг хөндөх, цэгцлэх цаг болсон гэж бодож байна. Мөрдөгдөж байгаа, бодуулсан долоон өөрчлөлт бүхий 1992 оны Үндсэн хууль түүхэн үүргээ сайн биелүүлсэн. Одоо өнгөрсөн 26 жилийн алдаа оноо, туршлагадаа тулгуурлан ирэх он жилүүдийн тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан шинэ Үндсэн хууль боловсруулж, батлах цаг болсон гэж бодож байна.

**-Эрх баригчид хүсэхгүй бол яах вэ?**

-Хүний эрхийг дээдэлсэн ардчилсан нийгэм, хувийн өмчийг зөвшөөрсөн зах зээлийн эдийн засаг руу шилжих 1990 оны түүхэн сонголт хийх үйл явцыг МоАХ манлайлж, Монголын ард түмэн уухайлан түрж дэмжсэний хүчинд бид их амжилт олсон. Үгүйгээр юм байхгүй. Одоо тэрхүү түүхэн сонголтыг төгөлдөржүүлэх, алдаа гажуудлыг нь засахын тулд Монголын ард түмний оюун санаа, эв нэгдлийн холбоо байгуулагдаж, ухаалаг давалгаалах цаг ирсэн. Эс тэгвэл Монгол Улсын хөгжил тушигдаж, хатингаршилд орох, улмаар бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд ч сүүдэр унах аюул нүүрлэж болзошгүй. Үүнийг мэдэрч байгаа хүмүүс эрх баригчдын дунд ч байгаа гэдэгт огт эргэлзэхгүй байна.

**-Сая та Үндсэн хуулийн шинэтгэл, тэр битгий хэл шинэ Үндсэн хууль баглах шаардлагатай гэж хэллээ. Хэрэв энэ Засгийн газар Үндсэн хуульд өөрчлөлт оруулчихвал нэг намын эрх ашиг агуулсан гэх шүүмжлэлээс хол байж чадах уу?**

-Урьдчилж үзмэрч шиг хандаад, хардаад байх хэрэггүй байх. Эрх барихаас дээгүүр эрх ашиг гэж бас байна шүү дээ. МАН дотор ч эрүүл саруул сэтгэдэг хүмүүс бий. Монголыг намаар хуваах хэрэггүй. Монгол Улс гэдэг чинь нэг том айл. Монгол бол улс төрийн нам үүсэхээс өмнө оршин тогтнож байсан, төрт ёсны их түүх, соёлтой үндэстэн. Монголын ардчилал бол П.Очирбат Ерөнхийлөгчийн хэлснээр, зөвшилцлийн ардчилал. Одоо ухаалаг, хариуцлагатай, ард түмний оролцоотой, хяналттай ардчилалтай болох хэрэгтэй байна.

**-АН-ын ҮЗХ хойшлогдсон шалтгаанд нэг л итгэл үнэмшил төрөхгүй байна гэж ярих хүмүүс байна?**

-Өмнө нь УИХ-аар ард түмний амьдралын чухал асуудал хэлэлцэх болсон тул гэсэн шалтгаанаар хойшлуулсан. Чухамхүү хойшлуулах биш, харин ч хуралдаж, ҮЗХ-ыхоо гишүүдийн үгийг сонсох ёстой байсан. Гэтэл одоо Орон нутгийн сонгууль гээд хойшлууллаа. Харин ч сонгууль болохоос өмнө хуралдаж, орон нутгаас ирсэн ҮЗХ-ны гишүүдээ тулгамдаж буй асуудал, жаргал

# П.Цагаан: АН-ЫН ШИНЭЧЛЭЛ ДҮРМЭЭ МӨРДДӨГ ДАРГАТАЙ БОЛОХООС ЭХЭЛНЭ

зөвлөнг нь сонсоод, байр сууриа илэрхийлээд, ажлаа уялдуулаад хамтраад явах хэрэгтэй баймаар. Ядаж тэр ирсэн гишүүдтэйгээ уулзаад зөвлөлдөөд явуулдаг байгаа даа. Өдөр тутам амьдрал дунд байгаа ҮЗХ-ны гишүүдийн харсан, үзсэн, мэдсэн, ажигласан зүйл, үнэтэй санал бодол ямар ч мундаг даргынхаас илүү. Дарга болохоороо ухаантай болчихлоо гэж андуурдаг гэм бий гэж Б.Чимид дарга байнга хэлдэг сэн. Тэр л болж байх шиг байна.

**-Тэгвэл та АН-аа гацаагүй ажилладаг, ядахдаа хурлаа хэвийн явуулдаг болгож шинэчлэхийн төлөө эн түрүүнд юу хийх ёстой гэж үзэж байна вэ?**

-Мэдээж дүрэмдээ суурь өөрчлөлт оруулах хэрэгтэй. Ингэхдээ АН-ын гишүүдээс асууя, гишүүдээ сонсоё, гишүүдээрээ шийдүүлье гэсэн зарчмын байр суурьтай байгаа. Фракциудын зөрчилд идэгдэж, намыг сульдүүлсан ҮЗХ-г татан буулгаж, оронд нь АН-ын 600-700 хүний бүрэлдэхүүнтэй Их хуралдай байгуулж, жилд нэг удаа тогтмол хуралддаг өдөртэй болох хэрэгтэй гэж үзэж байна. Их хуралдай ирцээрээ асуудлаа шийддэг байх нь зөв. Тэр өдөр нь намын дарга ИХ-г хуралдуулаагүй, ажлаа тайлагнаагүй бол даргаасаа чөлөөлөгддөг, дараагийн дарга

**Энэ тал дээр та ямар бодолтой байна вэ?**

-Бүгдээрээ зөвлөлдөөд шийдье л дээ. Миний бодлоор дээрх хоёр хувилбарын аль аль нь буруу гэж бодож байна. Хэдэн хүний тохироогоор сонгогдсон дарга Хурлаа хийхээр л огцорчих гээд байдгийг бид олон удаа харсан. Бид энэ алдаагаа давтаж болохгүй. Ийм учраас АН-ын даргыг дарга нар биш, АН-ын гишүүд, дэмжигчид сонгох эрх дархтай байх ёстой. Энэ удаад бараг ард нийтийн саналаар тодруулсан ч болно гэж бодож байна.

**-Асуулгүй өнгөрч боломгүй нэг асуулт байна. Хотын дарга Э.Бат-Үүл баатарыг С.Зоригийн хэрэгт холбогдуулан шалгаж эхэлсэн?**

-Э.Бат-Үүлийн мэдэгдлийг нь сонсоод гайхсан, почирдсон. 2000 оны сонгуулийн дараа бөөн дуулиан болгож баривчлаад, шалгаад дуусгасан гэж боддог байсан. Ер нь аливаа хүнийг гэмт хэрэгт холбогдуулан сэжигтэн, яллагдагчаар татна гэдэг хууль зүйн үр дагавартай, ноцтой асуудал. Хэдийгээр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцдоггүй ч гэлээ, тэдгээр байгууллагын тодорхой ажлын талаар олон үг хэлээд байх нь миний хувьд зохисгүй гэж бодож байна.

**-Гэвч та ямар төрийн алба хашиж байгаа биш таныг ажлаа өгснөөс хойш болсон, болж байгаа үйл явдлын талаар ярьж болно биз дээ?**

-Хувь хүний хувьд хэдэн үг хэлэе. Энэ жил, хэдхэн сарын өмнө дээрх хэрэгтэй холбогдуулан саалчын ч бил үү, малчин ч бил үү нэг хүнийг барьж хорьсон, хэрэг үүсгэж байгаа тухай хэвлэлд гарч байсан. Хэрэв тэр үнэн бол өнөөдөр Монгол Улсын баатар Э.Бат-Үүлийг уг хэрэгт хардаж, сэрдж байгаа юм байна. Тэгэхээр 18 жилийн өмнө гарсан гэмт хэргийн эзэн холбогдогчийг өнөөдөр Монголын тал нутаг дахь малчин, саальчнаас өгсүүлээд талийгаачийн журмын нөхөд, улстөрч гээд олон хүмүүсийн хооронд их л өргөн хүрээнд хайж, шалгаж байгаа нь гайхал төрүүлж байна. Хэргийн зурвас хумигдах биш, харин ч тэлж, хавтгайрч байна уу даа гэмээр сэтгэгдэл төрж байна. Хэдэн жилийн өмнө Цагдаагийн дарга "Хэргийн хүрээ хумигдлаа" гэж байсан. Үгүй л байж дээ. Энд нэг зүйл онцолж хэлэхэд, Бат-Үүл бол зөвхөн хотын дарга байсан Бат-Үүл биш. Монголд эрх чөлөө, ардчиллыг авчирсан хүмүүсийн нэг. Бат-Үүл бол дэлхийд данштай хүн. Олон улсын хүний эрхийн байгууллага Бат-Үүлийг сэжиглэж байгаа хэргийн мөрдөх ажиллагааг тавих гэж сонирхолтой байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Өнөөдөр бол 1937 он биш.

**-С.Зоригийг бүрэлгэсэн хэрэг хэзээ, яаж илэрнэ гэж боддог вэ?**

-Хэрэг илрээсэй л гэж байнга салбирдаг. Гэхдээ би олон жилийн өмнө нэг сонинд ярилцлага өгснөө саналаа.

**-Ямар ярилцлага?**

-1990-ээд оны эхээр АНУ-ын Тагнуулын төв газрын том албан тушаалтан Зөвлөлтийн тагнуул байсан тухай дуулиант хэрэг мандсан. Түүнийг яаж баривчилж, мөрдөж, шийтгэхийг, бас ашиглахыг ажигласан юм л даа. Тухайн үед тэр хүнийг баривчлах зөвшөөрөл олгосон шүүх хурлыг ТВ-ээр шууд дамжуулж байсан. Тэр этгээд ч хэргээ удалгүй хүлээсэн. Эх орноосоо урвасан зүйл ангиар шүүхээс насаараа хоригдох ял сонссон. Гэтэл дараа нь холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, товчоор хэлбэл, сул цэгээ мэдэж, ажлаа сайжруулахын тулд АНУ-ын Конгрессийн холбогдох байнгын хорооны зөвшөөрөлтэйгээр уг ялтнаас зөвлөгөө тусламж авч, ажилласан хоногийг нь ял эдэлсэн

хоногт тооцож байсан. Тэр жишгээс санаа аваад, бид уучлал, өршөөл зарлаад гэмт этгээдийг ялаас хэлтрүүлэнгээ хууль хяналтын байгууллагынхаа ажлыг сайжруулах, тийм гэмт хэрэг давтагдахаас урьдчилан сэргийлэх талаар ажиллаж болох юм биш үү гэсэн утгатай ярилцлагыг олон жилийн өмнө өгч байсан.

**-Та тэр урвагч, тагнуулчийг мөрдсөн, шийтгэсэн, бас ашигласан хэргийн нарийн ширийнийг яаж сайн мэдээд байна. АНУ-д ажиллаж байсан юм уу?**

-Тэр үед АНУ-ын Вашингтоны Их Сургууль, Конгрессийн номын сан, Сенатын шүүхийн хороонд судалгаа хийж, Үндсэн хуулийн эрх зүй, хүний эрх, үндэсний аюулгүй байдал зэрэг хичээлд сууж байсан болохоор ТВ үзэх, ном сонин унших завтай байсан. Миний дээр хэлдэг зүйл бол хэвлэл мэдээллийн нээлттэй эх сурвалжаас олж мэдсэн зүйл. Эх орноосоо урвасан онц хүнд ялтай гэмт хэргийн талаар ч гэсэн нийгэмд тодорхой мэдээлэл өгөхөөс гадна, шаардлагатай гэж үзвэл мэдлэг чадварыг нь төрд ашигладаг нь их содон харагдаж байсан.

**-Та бол Бат-Үүл баатарыг буруутай гэж огт үзэхгүй байгаа юм байна. Тийм үү?**

-Тийм ээ. Бат-Үүл бол ямар нэгэн харуу төлбөр нэхэхгүйгээр бусдын сайн сайхны төлөө, улсынаа төлөө амна золчихоос буцахгүй тийм үзэл бодолтой, хүмүүжилтэй хүн гэж би боддог, хүндэтгэдэг. Ардчилалд хүндрэл учрах болгонд зөвлөлддөг цөөн хүний нэг. Ний нуугүй хэлэхэд, чамайг ийм асуулт асууж байгаад чинь гайхаж байсан.

**-Бат-Үүл баатарын малгай тэднийхээс олдсон гэдгээр нь буруутгаад байдаг шүү дээ?**

-Энэ талаар Бат-Үүл олон удаа хэлж ярьсан биз дээ. Цагдаагийн хурандаа ч бил үү, ямар ч байсан нэр устай нэг офицер Бат-Үүлийн гэр нь ирээд аймшигт хэрэг гарсан тухай дуулианд Бат-Үүлийг дагуулаад талийгаачийн гэрт хамт очсон гэж байгаа. Айдас почролд автсан, бухимдсан олон хүн үймж байсан гэж байгаа. Тийм орчинд очоод, гарахдаа хүн малгайгаа байтугай пальтоогоо, ухаанаа ч орхиж болно шүү дээ. Үүнийг мухарлахад 18 жил хэрэгтэй болсон гэж үү? Бат-Үүлд алиби (alibi) байгаа бол түүнийгээ л нотлуулахад хангалттай баймаар.

**-“Алиби” гэж юу гэсэн үг болохыг уншигчдад тайлбарлаач?**

-Гэмт хэрэг үйлдэгдэх үед сэжигтэн өөр газарт байсныгаа бусад гэрч, баримтаар нотлохыг хэлж байгаа юм. Алиби нь нотлогдвол уг сэжигтэнийг нэн даруй суллаж, цагаатгах ёстой. Энэ бол эрүүгийн эрх зүйн сонгодог зарчим. Энэ бол аль Ромын эрх зүйгээс эхтэй боловч, эдүгээ заавал мөрдөгдөх олон улсын хэм хэмжээ. Өөрөөр хэлбэл, Бат-Үүл тэр аймшигт гэмт хэрэг үйлдэгдэх мөчид өөр газар, тухайлбал гэртээ унтаж байсан гэдгээ нотлоход л хангалттай гэсэн үг.

**-Тэгвэл ямар зорилгоор Бат-Үүл баатарыг дахин дахин шалгаад байгаа юм бол. Ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуультай ч холбож байх шиг?**

-Зорилгодоо байна уу, арга барилдаа байна уу харж л байя. За бид хоёрын яриа намын шинэчлэлийн сэдвээсээ багагүй хальчихлаа. Мэдээж Бат-Үүлийн асуудал ч бас шударга ёсны шалгуур дор яагдах ёстой. Тэр утгаар өөрийн байр суурийг хэллээ. Цаашид шинэчлэлийг өргөн хүрээнд цэгцтэй, бодлогын суурьтай харж байгаа. Намын шинэчлэлд сэтгэл зурх, гар бие, мэдлэг боловсролоо дайчлах, өөрчлөлтийг хүсч буй иргэн бүрт хамтран ажиллах санал тавьж байна.

**-За танд их баярлалаа. Намын шинэчлэлийн ажилд нь амжилт хүсье.**

...Хүний эрхийг дээдэлсэн ардчилсан нийгэм, хувийн өмчийг зөвшөөрсөн зах зээлийн эдийн засаг руу шилжих 1990 оны түүхэн сонголт хийх үйл явцыг МоАХ манлайлж, Монголын ард түмэн уухайлан түрж дэмжсэний хүчинд бид их амжилт олсон. Үгүйсгэх юм байхгүй...

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



# НАЙМААЧИД ЗАВШИЖ,

Машины эмийн санд тавигдах шаардлага, хууль эрхзүйн орчин манай улсад алга

Манай улсад хөлтэй бүхэн машин унаж байна гээд хэлчихэд хилсдэхгүй биз. Монгол улсын хэмжээнд 800 гаруй мянган бүртгэлтэй тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцдог гэсэн статистик мэдээлэл бий. Энэхүү мэдээллээс харахад 800 мянган жолооч ойролцоогоор 10000-30000 мянган хүнийг тээвэрлэж, тэдний амь насныг харууцаж байна гэсэн үг. Тэр хэрээр жолоочийн үүрэг хариуцлага нэмэгдэж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиа сахин биелүүлэх ёстой болж байна. Гэвч жолооч нарын хэдэн хувь нь хуулиа ягштал сахин биелүүлж байгаа бол. Тиймээс ч Замын цагдаагийн газар, Авто тээврийн үндэсний төв хамтран "Хяналт, шалгалт"-ын аян сарын хугацаанд эхлүүлээд буй. Тэгвэл тус аян дагаад галын хор, эмийн сан, ослын гурвалжин зарнагэх зарфэйсбүүк, твиттерээр явах болсон. Тиймээс бид дээрх зарын дагуу хэд хэдэн дугаарт залгаж үзэв. Манай сурвалжлах хэсгийн холбогдсон хүмүүс бүгд ямар нэгэн компани биш хувь хүн байсан бөгөөд БНХАУ-аас бараагаа оруулж ирдэг аж. Мөн галын хор, эмийн сан, ослын гурвалжин тус бүр 10 мянган төгрөгийн үнэтэй. Харин бүгдийг нь авбал 19.900 төгрөгийн үнэтэй байв. Түүнчлэн галын хор, эмийн санг нь авбал ослын гурвалжинг үнэгүй өгнө гэж байсан юм.

Харин бид эмийн хайрцагт нь юу байгааг сонирхоход "Анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай 11 дагалдах хэрэгсэл бий. Лент, спирттэй хөвөн, наалт, хайч байгаа.

...Монголд гал унтраадаг нэг компани байдаг. Тэндээ галын хор хийгээд таван цаасны илүү үнэтэй зарж болно шүү дээ. Монголчууд дотоодын бүтээгдэхүүнээ дэмжинэ. Би үүнд л харамсч байгаа. Яг үнэндээ Хятад улсад л хөрөнгө оруулаад байгаа юм...

Эм байхгүй. Хятадаас орж ирэхдээ ингэж ирдэг. Бид ямар нэгэн зүйл нэмж хийдэггүй. Үйлдвэрлэхдээ л анхны тусламжид шаардлагатай зүйлсийг хийсэн байдаг" гэсэн хариултыг өгсөн юм. Энд хэдэн жилийн өмнө болсон нэгэн үйл явдлыг сануулья. Энхтайвны гүүрэн дээр гарсан ослын улмаас амна алдсан харамсалтай хэрэг гарсан. Тухайн үед хажууд нь байсан жолооч нарын нэгэнд нь ч галын хор байгаагүй гэдэг. Ослын

газарт байсан нэг жолооч хэрвээ галын хор байсан бол нэг хүний амийг аврах байлаа гэж харамсч үйлж байсан гэх мэдээлэл ч тухайн үед гарсан. Энэ мэтчилэн дурдаад байвал бидний амьдралд сургамж болсон харамсалтай олон хэрэг бий. Эндээс бид сургамж аван худалдан авч байгаа галын хор, ослын гурвалжин чанарын шаардлага хангаж байна уу гэдгийг бодох л хэрэгтэй. Нэг удаа цагдаагийн нүдийг харуулаад онгөрөхийн тулд галын хор авдаг. Гэтэл яг хэрэгтэй тохиолдолд галын хор нь ажиллахгүй, ослын гурвалжин нь хугаараад унасан байвал яах вэ. Энэ бүгдийг бодож л үзэх хэрэгтэй. Мөн нөгөөтэйгүүр эмийн санд нь яг юу байх ёстой талаарх хууль эрхзүйн орчин ч манай улсад байдаггүй. Түүнээс болж жолооч нар элдэв янзын эм, нэг бэнт хийсэн болоод эмийн сантай болчихлоо гэх. Түүнийг ч нарийн шалгаж байгаа газар ч алга байна. Энэ талаар ЗЦГ-ын Урьдчилан сэргийлэх олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Х.Одбаяр "Эмийн сангийн хайрцаганд юу байх ёстойг би сайн мэдэхгүй. Тэр бол тухайн хүний сонголтын л асуудал. Тэр дотор толгойны эм, гэдэсний эм байх ёстой гэж тогтоосон стандарт, хууль эрхзүйн орчин одоохондоо байхгүй.

Түүнээс биш гэдэсний эм, толгойны эм аваагүй байна гээд цагдаагийн албан хаагч торгоод байгаа зүйл огт байхгүй" гэсэн юм. Хууль эрхзүйн орчин нь ч бүрдээгүй энэ нөхцөлд дуртай нэг нь эмийн сангийн хайрцаг оруулж ирээд түүн дотроо хэдэн спирттэй хөвөн, бэнт хийгээд дуртай үнээрээ жолооч нарт худалдаж байна. Жолооч нарч, цагдаа нар ч хор нь ажиллаж байна уу, эмийн санд нь ослын үед хэрэгтэй зүйлс



Гэрээ зургайга Г.АРГУУЖИН



## Төгсгөл. Түүрүүч нь I нүүрт

Тэгвэл уг торгуулийг нэг сарын хугацаанд орон даяар зохион байгуулан жолооч нарын халааснаас улсын төсөвт дөрвөн тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Тиймээс Замын цагдаа, хяналтын байцаагч нарт боломжтой бүх автомашиныг торгохыг үүрэгдсэн гэх мэдээлэл ч бий. Хэрвээ дээрх мэдээлэл үнэн бол нэг сар гэдэг улсын төсөвт дөрвөн тэрбум төгрөг биш гэхэд талыг нь суулгахад хангалттай хугацаа. Нэг л жишээ дурдъя. Манай улсын хэмжээнд нийт 300 мянган тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцдог байлаа гэж бодъё. Яахав, олны олон дотор хуулиа сахин биелүүлээд явж байгаа нэг хэсэг бий гэж үзээд 100 мянган машиныг торгуулийн жагсаалтаас хасъя. Мөн сарын хугацаанд ямар нэгэн шалтгаанаар замын хөдөлгөөнд оролцоогүй байх магадлалтай учраас дахиад 50 мянган машиныг хасчихъя. Ингээд нэг сарын хугацаанд үлдсэн 150 мянган машиныг зөвхөн 19200 төгрөгөөр торгоход л хоёр тэрбум 880 сая төгрөгийг жолооч нараас хураах бүрэн боломжтой. Энэхүү тоо баримтаас харахад л уг мэдээлэл ор үндэсгүй гэх баталгаагүй юм. Тиймээс бид уг мэдээлэл үнэн эсэхэд хариулт авахаар Замын цагдаагийн газрыг зорив. Манай сурвалжлах хэсгийн сонирхсон асуудалд замын цагдаагийн газраас нээлттэйгээр хариулт өгсөн юм. Ингээд бид ЗЦГ-ын Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Х.Одбаяраас хариулт авав.

Тэрбээр "Цахим ертөнц, зарим мэдээллийн сайтаар Замын цагдаагийн газраас жолооч нарыг торгож, улсын төсөвт дөрвөн тэрбум төгрөг төвлөрүүлнэ гэж мэдээлж, ярьж байна. Энэ бол огт ор үндэсгүй худал мэдээлэл. Улсын төсвийн бүрдүүлдэг Засгийн газрын агентлаг гэж бий. Татварын ерөнхий газар гэж бүхэл бүтэн тусдаа байгууллага байна. Харин

замын цагдаагийн газрын үндсэн чиг үүрэг гэвэл хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих юм. Замын хөдөлгөөний дүрэм болон хуульд заасан заалтыг жолооч нар дагаж, мөрдөх үүрэгтэй. Гэтэл үүргээ биелүүлээгүй байж замын хөдөлгөөнд оролцоод явж байгаа жолооч ч байна. Тэр жолоочид хариуцлага хүлээлгэхээс өөр аргагүй. Тэрнээс биш улсын төсөвт мөнгө төвлөрүүлнэ гэсэн зүйл байхгүй. Энэ бол огт худал мэдээлэл" гэв. Харин хяналт, шалгалтын тухай ярихдаа зөвхөн галын хор, эмийн сан, ослын гурвалжинг шалгаагүй. Өөр зүйлсийг ч шалгаж байгаа. Гэхдээ эдгээр зүйлс машинд заавал байх ёстой. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд ч эмийн сан, галын хор, ослын гурвалжинг машиндаа авч явах тухай заасан. Тиймээс жолооч нар хуулиа сахин биелүүлж, үүргээ ухамсарлах хэрэгтэй гэсэн юм. Замын цагдаагийн газраас улсын төсөвт дөрвөн тэрбум төгрөг төвлөрүүлэхийн тулд жолооч нарыг торгож байгаа гэдэг огт худал мэдээлэл гэдэг хариу өгсөн тул манай сурвалжлах хэсэг галын хор, ослын гурвалжин, эмийн сан худалдаалдаг наймаачидтай холбогдож ярилцсан юм.

## Хүчингүйд тооцов

9011174080 Улсын бүртгэлийн дугаартай, 5269024 регистрийн дугаартай Цэц консалтинг компанийн гэрчилгээг гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

Буян Маргад Од ХХК нь 5362318 регистрийн дугаартай тамга гээгдүүлсэн тул хүчингүйд

тооцов.

Цагаан шилмүүс ХХК-ийн 5189527 регистрийн дугаартай, 9011134046 улсын бүртгэлтэй компани нэрээ өөрчилж байгаа тул хүчингүйд тооцов.



**ХААН БАНК**

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2016.09.14

**ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЖ, СИСТЕМ ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ**

ХААН Банкны орон нутгийн салбар нэгжид ашиглагдах дохиоллын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж, суурилуулах, дохиоллын системийн үйл ажиллагааг 24 цагийн турш хянах мэдээ дамжуулах гэрээт компанийг сонгон шалгаруулах тул энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллагууд ХААН Банкны 50000045060000035 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхийг нөхцөлтэй тусгаж, бэримтэй оролцох хүсэлтийн албан бичгийн хамт Төв ХААН Банкны ресепшинд өгч, сонгон шалгаруулалтын өгөгдлийг авна уу.

Материалыг 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авах ба зөвхөн шалгарсан компани, аж ахуйн нэгжид бичгээр хариу мэдэгдэнэ.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Снүлийн гудамж-25, ш/х-192 Улаанбаатар 14250

Сонгон шалгаруулалтад хөлболой мэдээллийг россиян.тн 2016@khanbank.com хаягт хандаж авна уу.

Харилцах нийгэмдлийн тоо 1800-1917

www.khanbank.com

khanbank.com/facebook

khanbank.com/twitter

# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

байна уу гэдэгт хяналт тавьж байгаа ч юм алга. Нөгөөтэйгүүр жолооч нар анхны тусламжийн хэрэгсэл нь байгаа тохиолдолд яаж хэрэглэх талаарх мэдлэгтэй юу гэдэг мөн л бодох асуудал. Хуулийн цоорхойг ашиглаж наймаачид ашиг олоод л өнгөрнө. Харин эцэс сүүлд нь очуухэн зүйлд хайхрамжгүй хандаж, хямдхан чанар муутай галын хор, ослын гурвалжин худалдаж авсан жолооч нар л гашуун нулимстай үлдэнэ. Нэг хэсэг нь хууль эрхзүйн орчин бүрдээгүй учраас эмийн санд юу байх нь тухайн жолоочийн хэрэг гээд өнгөрөх, нөгөө хэсэг нь цагдаагийн нүдийг л хуурч байвал хямдхан юм байхад болно гэх хандлага нийгэмд байгаа нь сурвалжлагын явцад харагдаж байна. Мөн Замын цагдаагийн хяналт шалгалтыг дагаад үнийн хөөрөгдөл болсон гэж үзэх нэгэн ч таарч байв. Иймд бид жолооч нартай уулзаж, тэдний санаа бодлыг сонссон юм.

**Наймаачид хуулиар далимдуулж 3000 төгрөгийн үнэтэй ослын гурвалжинг 8000 болтол өсгөв**

зүйлсийг заадаг. Манай улсад тийм биш. Зүгээр л эмийн сан гээд л үзүүлэхэд л байж байвал болоо. Бид хэдэн маарал хийчихээд эмийн сан гээд байгаа болохоос яг хүнд хэрэгцээтэй зүйл байхгүй л болов уу. Ер нь манайд тийм зүйл байх ёстой гэж заагаагүй учраас л цагдаагийн нүдийг хуурахын тулд юу ч хамаагүй л хийгээд явж байгаа шүү дээ, жолооч нар. Ослын тэмдгийг 3000 төгрөгөөр л авсан. Ер нь дороо л эвдэрчихдэг. Машин дотор явж байгаад л салаад уначихдаг юм.

**Б.ГАНТУЛГА: ЯГ ҮНЭНДЭЭ ХЯТАД УЛСАД Л ХӨРӨНГӨ ОРУУЛААД БАЙГАА ЮМ**

-Дүрмэндээ галын хор, ослын гурвалжин, эмийн сан байх ёстой гэж заасан байдаг. Манайхан өөрсдөө заавал шахааж шаардуулж, аян өрнүүлж байж л юмыг биелүүлэх гээд байдаг талтай. Энэ хэн хэнийг нь хариуцлагын асуудал. Энэ аян явагдаж байгаа нь зөв. Гэхдээ үүнийг дагаад хятадын чанар муутай галын хор, ослын гурвалжин, эмийн сан зарагдаад байгаа нь таалагдаагүй. Нүглийн нүдийг гурилаар хуурна гэгчээр ёстой муухай зүйл. Цаагуураа бизнес явагдаад байгаа юм болов

үед фэйсбүүкээр 15, 19 мянга гээд эмийн сангийн зар яваад байна лээ. Жижигхэн улаан галын хор харагдаж байсан. Тэр бол жинхэнэ нүглийн нүдийг гурилаар хуурсан л зүйл. Мөн нөгөө талаар өөр орныг санхүүжүүлж байна л гэсэн үг. Монголд гал унтраадаг нэг компани байдаг. Тэндээ галын хор хийгээд таван цаасны илүү үнэтэй зарж болно шүү дээ. Монголчууд дотоодын бүтээгдэхүүнээ дэмжинэ. Би үүнд л харамсч байгаа. Яг үнэндээ Хятад улсад л хөрөнгө оруулаад байгаа юм.

**Ч.ШИНЭБАЯР: ГАЛЫН ХОР, ГУРВАЛЖИН ХОЁР Л СТАНДАРТ БАЙВАЛ ЭМИЙН САНД ЮУ БАЙХ НЬ ХАМААГҮЙ**

-Цагдаагийн хувьд тавих ёстой л шаардлага. Яахав тэрийг дагаад бизнес явах нь зах зээлийн л асуудал. Надад хуучин ослын гурвалжин галын хор байсан. Эмийн сан л нэмж авсан. Ер нь эмийг заавал зориулалтын саванд хийнэ гэсэн зүйл байхгүй. Тийм ч шаардлага цагдаа нар тавихгүй байгаа. Галын хор, гурвалжин хоёр л стандарт байвал эмийн санд юу байх нь хамаагүй. Эм нь байгаад ууттай байвал л болно. Миний

эмийн санд толгойны эм, цус тогтоодог тос гэх мэт ойр зуурын л зүйлс бий. Өмнө ч гэсэн шалгадаг л байсан. Энэ заавал цагдаа гээд байлгүй хувь хүний ухамсрын л асуудал. Жолооч хүний хийх ёстой зүйлс. Тэр цагдаа гэмтэхгүй. Ямар нэгэн байдлаар осол гарлаа гэхэд цагдаа гэмтэхгүй. Бид л гэмтэнэ.

**Б.ОДБИЛЭГ: 3000 ТӨГРӨГИЙН ҮНЭТЭЙ БАЙСАН ОСЛЫН ГУРВАЛЖИН 8000 ТӨГРӨГ БОЛСОН**

-Мэдээж хэрэг галын хор, ослын гурвалжин, эмийн сан байх нь миний аюулгүй байдалд хэрэгтэй. Үүнийг зөв зүйл гэж боддог. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан шүү дээ. Тиймээс бид биелүүлэх л ёстой. Гэхдээ хүчээр огцом цаанаас нь зохицуулчихаар үнийн хөөрөгдөл болоод байна. Тухайлбал, 3000 төгрөгийн үнэтэй байсан ослын гурвалжин 8000 төгрөг болтлоо өссөн. 2500 байсан эмийн сан нь 6000 төгрөг болсон. Яахав жолооч нарыг торгоод байхаар тэр үнэтэй зүйлсийг авахаас өөр аргагүй. Тодорхой хугацаа өгөөд, энэ хугацаанд ийм зүйлстэй болсон байх ёстой гэвэл

үнийн хөөрөгдөл арай гайгүй байсан болов уу. Шууд шаардаад, торгоод эхэлчихээр наймаачид нь үнээ нэмчихдэг. Тэрнээс болж зарим жолооч бэлгэдлийн журмаар хамгийн мууг нь авч байна. Эмийн сан дотор өөрт нь хэрэгтэй зүйл байна уу гэдэг гол биш. Цагдаад үзүүлэхийн тулд л аваад байдаг. Уг нь ядаж л цус алдсан тохиолдолд хэрэг болох зүйл л байх ёстой. Одоогийн байдлаар хүмүүсийг хараад байхад цагдаагийн нүдийг хуурах гэсэн л юм аваад байна. Галын хор нь гарах ч юм уу, гарахгүй ч юм уу тэр огт хамаагүй. Ослын гурвалжин нь тогтохгүй хугаарад уначихмаар тийм эмзэгхэн юм л тавиад байгаа. Би олонхын жишгийг дагаад Өгөөмөр захаас галын хор, ослын гурвалжин, эмийн санг 38 мянган төгрөгөөр авсан. Өмнө нь аваагүй байсан юм. нэг удаа цагдаа зогсоогоод бичиг баримт хурааж авсан юм. Тэгээд л авах шаардлагатай болсон.

**М.ЭНХТӨР: БИ 20 МЯНГАН ТӨГРӨГӨӨР ЧАНАРТАЙГ НЬ АВСАН**

-Энэ бол жолоочийн хариуцлага. Би 20 мянган төгрөгөөр Да хүрээ захаас худалдаж авсан. Гэхдээ

чанартайг нь авсан л даа. Эмийн сандаа овчин намдаах эм нэмсэн. Дотроо бент, боолт харагдаж байсан. Юу байгааг нь сайн анзаарч, тогтож үзээгүй.

**Л.БОЛОРЦЭЦЭГ: ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААЧИХСАН ЗҮЙЛС**

-Хүмүүс цагдаа нарыг шаардаж байна гээд байгаа. Гэхдээ энэ чинь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заачихсан. Тиймэрхүү зүйлийг авч явж байж л машин тэрэгтэй харьцаж, хүн тээвэрлэнэ биз дээ. Харин манай улсад ямар нэгэн зүйл болохоор л нэг төрлийн бизнес хөгжөөд байдаг. Үүнд төр засгаас анхаарч, зохицуулаад өгвөл жолооч нарт ч ашигтай. Энэ ажил нь ч гэсэн үр дүнтэй ухаалаг болох байх. Түүнээс биш нэг юм хийхээр л нөгөө юм нь хөл толгой нь мэдэгдэхгүй үнэтэй болоод байвал хэцүү шүү дээ.

**Б.БАТЗОРИГ: МАНАЙХАН Л НЭГ ИХ ООШООДОГТҮЙ БОЛОХООС МАШИНД БАЙХ ЁСТОЙ ЗҮЙЛҮҮД**

-Хууль, дүрмэндээ нэмэлт

# ЖОЛООЧ НАР ХОХИРЧ ҮЛДЭХ НЬ...

**Н.ОДБАЯР: БИД ХЭДЭН МАРАЛ ХИЙЧИХЭЭД ЭМИЙН САН ГЭЭД БАЙГАА БОЛОХООС ЯГ ХҮНД ХЭРЭГЦЭЭТЭЙ ЗҮЙЛ БАЙХГҮЙ Л БОЛОВ УУ**

-Галын хорыг хэрэглэж байж л мэднэ үү гэхээс биш гаднаас нь хараад мэдэхгүй шүү дээ. Он сарыг нь хараад ч мэдэхгүй. Уг нь бол байх л ёстой. Одоо эмийн сан, галын хоргүй жолооч гэж байхгүй байх л гэж бодож байна. Галын хор анх машин авахад дагалдаж ирсэн. Харин би зогсоолын тэмдэг худалдаж авсан. 3000 төгрөг л гэдэг юм билээ. Эмийн санд бол эм, бентхэн л байгаа. Манай улсад ямар орос шиг сүрхий шаардлага тавих биш. Оросод бол заавал цус тогтоох жигүүт байх ёстой гэдэг. Эмийн санд байх ёстой

уу гэж бодогдсон. Энийг л хүмүүс эсэргүүцээд байгаа юм. Тэрнээс биш байх ёстой зүйлс байх нь зөв. Ер нь гадуур үнэтэй, хулир байна гээд яриад байгаа. Би том галын хортой. Дельтай авто сервисээс цэнхэр эмийн сан авсан. Машинны эмийн санд баахан эм байх ёстой гэж жолооч нар ойлгоод байдаг. Тэгээд л ямар ч хамаагүй эм хийдэг. Тэр бол маш буруу. Ямар нэгэн осол гарлаа гэж бодоход анхан шатны тусламж үзүүлэх учраас боолт, хөвөн, бент, нод байх ёстой. Одоо гадуур зарагдаад байгаа машины эмийн санд ойр зуурын толгой, гэдэсний эм байх жишээтэй. Яг юунд хэрэглэх гээд байна гэдгээ утгачилж ойлгох л хэрэгтэй. Миний авсан эмийн сан дотор нойтон салфетка, хөвөн, бент, нод байсан. Түүнээс толгойны эм байдаггүй байхгүй юу. Сүүлийн



хэрэгсэл авч явах ёстой гэж заадаг. Тиймээс байх л ёстой асуудал. Хээр хөдөө явж байхад их хэрэг бодог зүйлүүд л дээ. Манайхан л нэг их оошоож үздэггүй. Шалгадаггүй болохоор нэг их хэрэглэдэггүй юмшиг байгаа юм. Одоо шалгаад ирэхээр хэрэглэж эхэлж байна. Тэр болгон дэлгүүр, зах хэсэх боломжгүй хүмүүс байгаа. Тэгэхээр гадуур зарж байгаа нь байж болох л асуудал. Би үзлэгт орох шаардлагатай болсон юм. Үзлэгт ороход эдгээр зүйлсийг шалгаж байна лээ. Тэгээд л ойролцоох газраас нь авсан. Өмнө нь шалгадаг байсан ч заавал ав гэдэггүй зүгээр аваарай гээд сануулаад өнгөрдөг байсан.



## ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 5000 SERIES



### БИД ТАНЫ АЖЛЫГ ХӨНГӨВЧИЛНӨ

Inspiron 15 5000 загварын нөүтбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан Full HD дэлгэц, гайхалтай график үзүүлэлт, Intel® Core i5 процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

### Онцгой урамшуулал

Dell брэндийн нөүтбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аваарай.



### Бэлгэнд

- Үүргэвч
- 2 жилийн баталгаа
- McAfee вирусын програм

[www.facebook.com/PCmallOfficial](http://www.facebook.com/PCmallOfficial)  
[www.instagram.com/PCmall\\_Official](http://www.instagram.com/PCmall_Official)

Биднийг дагаарай  

 7575-3535

Хаяг: PC Mall төв: Их сургуулийн гудамж 31/1, Ш/Х: 346, Улаанбаатар - 14193, Сүхбаатар дүүрэг - 8



## Амралтын цаг



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр 18  
Шөнө 6

Нөгөөдөр  
Өдөр 13  
Шөнө 7

Өдрийн зурхай

Намрын дунд улаагчин тахиа сарын Дөрвөн ногоон мэнгэтэй Улаан морь өдөр. Буд гараг

Үс засуулбал: Өлсөж ундаасна  
Наран ургах, шингэх: 06:37 - 18:51



Өдрийн өнгө: Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биез энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, тал, адегуус туулах, лусыг тахиx, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэлцэл хийх, сэтгэлд сэтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### ДУУЛГАХ СОНИН




### Паралимпийн тамирчид маргааш эх орондоо ирнэ

Бразилийн Рио де Жанейро хотноо болсон Зуны XV паралимпийн наадамд эрхээ авсан найман тамирчин, таван дасгалжуулагчийн хамт оролцож, бахархам амжилт үзүүлсэн билээ. Тодруулбал, жүдоч Б.Ууганхүү пауэрлифтингийн төрлөөр анх удаа оролцсон Э.Содномпилжээ нар хүрэл медаль хүртэж, паралимпийн медальтан болсон. Мөн байт харвааны

холомог багт "Бээжин 2008" паралимпийн аварга, Хөдөлмөрийн баатар Д.Баатаржав, хоёр дахь наадамдаа оролцсон Б.Оюун-Эрдэнэ нар 40 орноос чансаагаараа шилдэг 16-д багтаж, Герман, Польшийн багийг хожин IV байр эзлэв. Паралимпийн наадмын хөнгөн атлетикийн бөөрөнцөг түлхэлт, зэрээнцэг шидэлтээр анх удаа оролцсон Г.Цогтгэрэл бөөрөнцөгөөр V байр

эзлэхдээ Азийн рекордыг хоёр удаа шинэчлэн тогтоогоод зогсохгүй Риогийн наадамд амжилттай оролцсон Монгол Улсын баг 160 орноос 75 байрт жагссан амжилтыг үзүүлсэн юм. Тэгвэл паралимпийн наадамд оролцсон Монголын баг тамирчид маргааш 00.00 цагт Бээжингийн нислэгээр Улаанбаатарт газардах юм байна.

### Бидэнд тохиолдсон



Zorigt Otgoо



КҮНДХЭН ХӨГТЭИ  
ЯВДЛУУД

Ээжтэй утсаар ярьж байгаад "За тэгээд монголоор өөр сонин юу байна" гэсэн чинь "Тал нь самарт яваад л, тал нь солонгос яваад л хямрал үргэлжилж байна" гэдэг байгаа. Бодвол үлдсэн тал нь самар цөмөөд л ажил хичээлдээ жирийн байгаа байхдаа. Хаха

### ОДДЫН АМЬДРАЛ



### ЖЕННИФЕР ЛОПЕЗ Харристай нууцаар болзжээ

Дуучин Тайлор Свифтээс салснаасаа хойш DJ Калвин Харрис олон эмэгтэйтэй нэр холбогдож эхлэв. Гэхдээ хамгийн сонирхолтой нь түүний болсон эмэгтэйчүүдийн дунд саяхан залуухан амрагаасаа салж, ганц бие болсон дуучин, жүжигчин Женнифер Лопез багтаж байна. Энэ сар гарсны дараа Мексикийн жүжигчин бүсгүйтэй гар гараасаа хөтлөцлөн алхаж, шар хэвлэлийнхний анхаарлыг татаж байсан DJ залуу саяхан Женнифер Лопезтой болсон гэнэ. Гэхдээ тэдний болзоо тун нууцлаг байдалд өрнөсөн сурагтай. Тэд хүнд харагдахыг хүсээгүй төдийгүй олны анхаарлаас холдохын тулд Лас Вегасын нэгэн зочид буудалд хоёулаахнаа цагийг өнгөрүүлжээ. Дуучин бүсгүйн хувьд жүжигчин Каспераас салаад удаагүй байгаа юм.

### Жастин Бибер ДАХИАД ГАНЦ БИЕ БОЛЛОО

Загвар өмсөгчид, олны танил залуу бүсгүйчүүдийг оймс шигээ сольдог гэдгээрээ алдартай Канадын дуучин Жастин Бибер ганц бие болжээ. Тэрбээр өнгөрсөн сараас эхлэн Софи Ричи гэх загвар өмсөгч бүсгүйтэй болж эхэлсэн байдаг. Гэвч тэдний харилцаа төд удалгүй төгсгөл болжээ. Софи, Жастин нарын харилцаа тун дуулиантай эхэлсэн.

Тодруулбал, Жастин Бибер шинэхэн найз бүсгүйнхээ зургийг инстаграмм хуудаастаа нийтэлснийхээ дараа шүтэн бишрэгчдийнхээ эцэс төгсгөлгүй шүүмжилсэн сэтгэгдлээс залхаж, инстаграмм хуудсаа хаахад хүрсэн удаатай. Гэхдээ тэдний үерхэл ердөө зургаан долоо хоногийн настай байсан төдийгүй зун дуусахтай зэрэгцэн замхарчээ.



90-ээд оны үед залуусын дунд нэрд гарч байсан хамтлаг тодорхой шалтгааны улмаас тарцгааж киноны үйл явдал эхэлнэ. Залуус тус тусын амьдралыг хөөж 20 жил өнгөрсний дараа хамтлагийн нэг гишүүн эргэн нэгдэх санал тавьж үйл явдал өрнөх болно. Урлаг тэднийг хүлээн авах болов уу?



Артур Бишоп урьд хийдэг байсан ажлаа орхиж тайван амьдрахыг хүссэн боловч түүний дайснууд хайртай бүсгүйг нь олзолно. Яах ч аргагүй байдалд орсон тэрээр дэлхийн талыг туулж 3 том аллага үйлдэх хэрэгтэй болдог. Гэвч энэ бүх ажиллагаа санаандгүй болсон мэт харагдах ёстой.

Урлаг үйл гэнэ исийн дэлгэцэнээ

